

Хамжиж угсарсан нийлмэл үгийг тохирох жишээтэй нь зөв харгалзуулаарай.

	Хамжиж угсарсан нийлмэл үг бүтэх
1	Өнгө зүс заасан тэмдэг нэр + жинхэнэ нэртэй хамжих
2	Голдуу таван хошуу малын холбогдолтой жинхэнэ нэр + амьтан, ургамал, зэвсэг хэрэглэл, бодис юмсыг заасан жинхэнэ нэртэй хамжих
3	Байгалийн төрөл бүрийн бодис юмсыг нөгөө бодис юмтай жишиж
4	Орон цаг, учир шалтгааны холбогдол бүхий хоёр жинхэнэ нэр нэг нь нөгөөдөө үндсээрээ захирагдаж
5	Өнгө зүс заасан тэмдэг нэр нэг нь нөгөөдөө үндсээрээ холбогдож
6	Өнгө зүс заасан тэмдэг нэр + тухайн өнгө зүсний дээд чанарыг агуулсан юмсын нэртэй хамжих
7	Орны холбогдолтой цөөн жинхэнэ нэр + өнгө зүс заасан тэмдэг нэртэй хамжих

Жишээ нь:
А. бөөр алаг, магнай халзан, омруу цагаан
Б. гар чийдэн, гэрэл зураг, гар бөмбөг, дунд сургууль
В. үнсэн саарал, гал улаан, сувдан цагаан, шаазгай алаг
Г. морин хийл, үхэр цох, ямаан бүрээ, хонин гүрвэл
Д. хар хээр, хар алаг, улаан буурал, улаан зээрд,
Е. усан үзэм, мөнгөн ус, мөсөн чихэр, элсэн чихэр, суман могой
Ё. хөх бух, шар шувуу, алаг туу, улаан булан, бөөр алаг, магнай халзан, омруу цаг